



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/86

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж” худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

3.“Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж” худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 22-ний өдрийн А/8 дугаар
захирамжийн хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ХӨВСГӨЛ АРБУЛАГ, ГАЛТ,
ШИНЭ-ИДЭР, РАШААНТ, ТАРИАЛАН, ТӨМӨРБУЛАГ, ТОСОНЦЭНГЭЛ, ХАНХ, ЦАГААН-ҮҮР,
ЦАГААННУУР/ СУМДАД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	УАЗ Хантер авто машин /Хөвсгөл хүрээнд Шинэ-Идэр, Төмөрбулаг, Галт, Рашаант, Ханх, Цагаан-Үүр, Цаганнуур сумдын Засаг даргын Тамгын газарт/	7	532,000,000
2	SUZUKI JIMNY авто машин /Хөвсгөл Арбулаг, Тосонцэнгэл, Тариалан сумдын Засаг даргын Тамгын газарт/	3	327,000,000
3	Хөвсгөл багийн Засаг дарга нарт мотоцикль	5	21,000,000
Нийт дүн			880,000,000

оОо